

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн “Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа” УТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/015/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Эрдэнэт хот 2026 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Л.Болормаа Утас: 70350757 Цахим хаяг: bolormaal@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.13 № 88
танай _____-ны № _____-г

“ЭРДЭНЭТ ЦЭЦЭРЛЭГТ
ХҮРЭЭЛЭНГИЙН АШИГЛАЛТЫН
ӨМНӨХ ЗАХИРГАА” УТҮГ-ЫН ДАРГА
М.ЭНХБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа" УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа" УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд аймаг, сумын хөрөнгө оруулалтаар 63,501.5 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж авч, санхүүгийн тайланд тусгасан байна.

Байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд А/1002 улсын чанартай авто замын засварын ажилтай холбоотойгоор Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу гэрээ

612505487

байгуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллага нь 2025 онд иргэдэд ээлтэй, аюулгүй, тогтвортой үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт, 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлт нь 92.5 хувьтай ажилласан байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр /	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>27,477,162.43</u>	<u>40,408,680.16</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>34,643.43</u>	<u>2,112,018.58</u>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	<u>34,643.43</u>	<u>2,112,018.58</u>
3121	Төгрөг		
31213	Арилжааны банкин дахь харилцах	<u>34,643.43</u>	<u>2,112,018.58</u>
33	АВЛАГА		<u>47,974.58</u>
331	Ажиллагчидтай холбогдсон авлага		<u>47,974.58</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>27,442,519.00</u>	<u>38,248,687.00</u>
351	Түүхий эд материал	<u>19,272,400.00</u>	<u>26,840,300.00</u>
3511	Тусгай зориулалттай материал	<u>19,272,400.00</u>	<u>26,840,300.00</u>
3513	Эм боох материал		
354	Хангамжийн материал	<u>1,323,619.00</u>	<u>11,408,387.00</u>
3541	Бичиг хэргийн материал	<u>30,000.00</u>	8,000.00
3542	Аж ахуйн материал	<u>464,000.00</u>	<u>2,309,500.00</u>
3544	Түлш,шатах тослох материал	<u>629,619.00</u>	<u>184,387.00</u>
355	Биологийн хөрөнгө	<u>6,846,500.00</u>	<u>8,906,500.00</u>
36	Нөөцийн бараа		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,334,181,648.76</u>	<u>4,119,928,056.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>4,334,181,648.76</u>	<u>4,119,928,056.45</u>
392	Биет хөрөнгө	<u>4,334,181,648.76</u>	<u>4,119,928,056.45</u>
39201	Барилга, байгууламж, орон сууц	<u>5,323,447,039.32</u>	<u>5,323,447,039.32</u>
39202	Хуримтлагдсан элэгдэл	<u>(1,155,126,307.00)</u>	<u>(1,394,590,378.87)</u>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	<u>15,500,000.00</u>	<u>40,085,000.00</u>
39204	Хуримтлагдсан элэгдэл	<u>(14,900,000.00)</u>	<u>(16,149,375.00)</u>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	<u>253,900,109.00</u>	<u>290,561,710.12</u>
39206	Хуримтлагдсан элэгдэл	<u>(105,266,961.56)</u>	<u>(137,634,815.90)</u>
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	<u>33,210,810.00</u>	<u>33,210,810.00</u>
39208	Хуримтлагдсан элэгдэл	<u>(16,583,041.00)</u>	<u>(19,001,933.22)</u>
39214	Бусад үндсэн хөрөнгө		
39215	Хуримтлагдсан элэгдэл		
393	Биет бус хөрөнгө	<u>1,200,000.00</u>	<u>1,200,000.00</u>
39301	Програм хангамж	<u>1,200,000.00</u>	<u>1,200,000.00</u>
39302	Хуримтлагдсан элэгдэл	<u>(1,200,000.00)</u>	<u>(1,200,000.00)</u>
39303	Бусад биет бус хөрөнгө		
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,361,658,811.19</u>	<u>4,160,336,736.61</u>
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
4131	Ажиллагсадтай холбогдсон өглөг		
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг өглөг		
4136	Бусад өглөг		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,361,658,811.19</u>	<u>4,160,336,736.61</u>

51	Засгийн газрын хувь оролцоо	<u>4,361,658,811.19</u>	<u>4,160,336,736.61</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		<u>5,629,976,249.70</u>
51101	Өмч: - төрийн	<u>4,911,202,136.75</u>	
512	Хуримтлагдсан үр дүн	<u>(961,852,350.32)</u>	<u>(1,469,639,512.89)</u>
5121	Өмнөх үеийн үр дүн	<u>(961,852,350.32)</u>	<u>(1,268,317,438.51)</u>
5122	Тайлант үеийн үр дүн	412,309,024.76	<u>(201,322,074.58)</u>
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,361,658,811.19</u>	<u>4,160,336,736.61</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (цэвэр)	1,154,837,045.02	609,709,136.12
2	Борлуулалтын өртөг	742,528,020.26	811,031,210.70
3	Нийт ашиг (алдагдал)	412,309,024.76	(201,322,074.58)
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Борлуулалт, маркетингийн зардал		
8	Ерөнхий ба удирдлагын зардал	341,785,613.24	430,633,302.49
9	Санхүүгийн зардал	83,278,766.91	<u>99,442,774.78</u>
10	Бусад зардал	317,463,640.11	277,000,193.43
11	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/		3,954,940.00
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	412,309,024.76	(201,322,074.58)
13	Орлогын татварын зардал		
14	Татварын дараах ашиг (алдагдал)	412,309,024.76	(201,322,074.58)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	412,309,024.76	(201,322,074.58)
16	Орлогын нийт дүн		
17	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	429,168,700.00	544,112,900.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	429,168,700.00	544,112,900.00
1.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	429,168,700.00	544,112,900.00
1.2.1	Ажиллагчдад төлсөн	302,657,359.25	377,707,628.23
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	39,128,253.99	52,973,648.84
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	46,181,512.50	44,149,564.14
1.2.4	Бичиг хэрэг	677,750.00	1,629,800.00
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	38,154,508.10	54,820,666.14
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	2,350,000.00	3,500,000.00
1.2.10	Бусад мөнгөн зарлага		
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,316.16	5,277,375.15
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		3,200,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		3,200,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		3,200,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	19,316.16	2,077,375.15
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.2	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,327.27	34,643.43
7	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,643.43	2,112,018.58

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	4,911,202,136.75		(549,543,325.56)	4,361,658,811.19
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			(201,322,074.58)	(201,322,074.58)
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,911,202,136.75		(750,865,400.14)	4,160,336,736.61

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад залруулга хийгээгүй болно.

Аудитаар нийт 1,503.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,503.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Даргын тушаалаар 2 сар 20 хувийн цалин хасах сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчийн 557.6 мянган төгрөгийн суутгал хийгээгүй олгосон, нийт албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг 616.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон, 330.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, тайлагнаагүй зөрчлүүдэд 3 төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын тайланд 3,534.7 мянган төгрөгийн шатахууны зардлыг нийт дүнгээр нь бүртгэж, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;", 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүр орлого", Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 8 дугаар бүлгийн 8.21-т "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ", гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж 1:

Шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэж байх.

2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд кассын орлогыг бүртгэл тайланд тусгалтгүй 330.0 мянган төгрөгөөр урсгал засвар хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх;", 5.1.5-т "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Орхон аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 сарын 24-ны 02/18 тоот тогтоолын гуравдугаар хавсралтаар "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын 3.3-т "Шууд түрээсийн орлогыг 100 хувь, дам түрээсийн орлогын 60 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж 2:

Түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байх

3. Шилэн данстай данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим системд оруулбал зохих мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ талбар болон бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн нийт 2 талбарт 9,538.7 төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх;", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6.1.3-т " дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж 3:

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд иж бүрэн оруулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Даргын тушаалаар 2 сар 20 хувийн цалин хасах сахилгын шийтгэлтэй 1 албан хаагчийн 557.6 мянган төгрөгийн суутгал хийгээгүй олгосон	1	557.6	1	557.6								
Нийт албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг 616.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон	1	616.2	1	616.2								
330.0 мянган төгрөгийг бэлнээр авч зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй, тайлагнаагүй	1	330.0	1	330.0								
шатахууны 3,534.7 мянган төгрөгийг, бараа материалын тайланд нийт дүнгээр нь бүртгэж зарцуулалт хийсэн	1	-					1	-				
Тайлант онд 330.0 мянган төгрөгийн засварын зардлыг анхан шатны бүрдэл хангахгүй кассаар зарцуулалт хийсэн	1	-					1	-				
Дүн	5	1,503.7	3	1,503.7			2	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим системд оруулбал зохих мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ талбар болон бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр гэсэн нийт 2 талбарт 9,538.7 төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.	1	-					1	-
Дүн								-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								